



Захирлын 2016 оны 06 дугаар сарын 07 -
ны өдрийн 4 дугаар тушаалын 1 дугаар
хавсралт

МУИС-ИЙН БАЙГАЛЬ-ЭХ ЛИЦЕЙ АХЛАХ СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧ ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ

1. МУИС-ийн харьяа Байгаль-Эх лицей ахлах сургуулийн байгалийн ухааны гүнзгийрүүлсэн сургалттай 10-р ангид нийслэл хот болон хөдөө орон нутгаас суралцагч элсүүлэхэд энэхүү журмыг баримтална.
2. Байгаль-Эх лицей ахлах сургуульд элсэхээр бүртгүүлэгч, элсэгч болон элсэлтийн комиссын үйл ажиллагааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.
3. Байгаль-Эх лицей ахлах сургуульд элсэхээр хүсэлт гаргасан сурагчийг "бүртгүүлэгч", зохих болзол хангаж элсэлтийн хяналтын тоонд багтсан бүртгүүлэгчийг "элсэгч", элсэлтийн үйл ажиллагааг нэгдсэн байдлаар зохион байгуулахаар томилогдсон комиссыг "элсэлтийн комисс", элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулахад оролцох ажилтныг "комиссын гишүүн" гэнэ.
4. Байгаль-Эх лицей ахлах сургуульд суралцагч элсүүлэх ажлыг МУИС-ийн захирлын тушаалаар томилсон комисс зохион байгуулна.
5. Бүртгүүлэгч бүртгүүлэхээс өмнө энэхүү журамтай танилцах үүрэгтэй.
6. Энэхүү журам болон нэмэлт мэдээллийг <http://www.num.edu.mn/> <http://eecbehs.num.edu.mn/> цахим хуудсанд байрлуулна.
7. Энэхүү журмаар зохицуулагдахгүй асуудал гарвал МУИС-ийн Захирлын тушаалаар байгуулагдсан элсэлтийн комисс шийдвэрлэнэ.
8. Тус сургуульд элсэхийг хүссэн, суурь боловсролын /9-р анги төгссөн/ гэрчилгээтэй суралцагчдыг бүртгэнэ. Улсын математик, физик, хими, биологи, газарзүй, мэдээлэл зүйн олимпиадад оролцсон суралцагчдыг тус сургуулийн 10-р ангид шалгалтгүй элсүүлж гүнзгийрүүлсэн сургалтын төлбөрийг хөнгөлнө.
9. Нийт бүртгүүлэгчдээс элсэлтийн шалгалтыг математик, физик, хими, англи хэлний хичээлээр ЕБС-ийн 9 дүгээр ангийг төгсөгчдийн эзэмшсэн байх агуулгын хүрээнд бичгээр авах бөгөөд математикийн шалгалт нь суурь шалгалт байна. Математикийн хичээлийн шалгалт 50 оноо, физикийн хичээлийн шалгалт 20 оноо, химийн хичээлийн шалгалт 20 оноо, англи хэлний хичээлийн шалгалт 10 оноо, нийт 100 оноо байна.
10. Математикийн хичээлийн шалгалтыг уламжлалт аргаар /бодолт/, физик, хими, англи хэлний хичээлийн шалгалтыг тест болон бичвэрийн арга хослон авна.
11. Элсэлтийн шалгалтанд орсон суралцагчдыг шалгалтын нийлбэр оноогоор жагсаан хяналтын тоонд багтааж элсүүлнэ. Оноо тэнцсэн тохиолдолд суурь боловсролын гэрчилгээний дундаж оноогоор байр эзлүүлэх ба суурь боловсролын гэрчилгээний дундаж оноо тэнцвэл математикийн хичээлийн дүнг харгалзана.

12. Элсэлтийн шалгалтын хэлбэр, асуулт даалгавар, сэдэв боловсруулах, шалгалтын хугацаа ба үнэлгээний шалгуур тогтоох, нууцлал хадгалах зэрэг асуудлыг элсэлтийн комиссын дарга, нарийн бичгийн дарга, комиссын гишүүд хариуцна.

13. Элсэх зохих болзол хангаж, хяналтын тоонд багтсан бүртгүүлэгчдэд зарласан өдрийн 9:00-18:00 цагийн хооронд элсэх эрх олгоно. Бүртгүүлэгч элсэх эрхээ авахдаа дараах материалыг бүрдүүлнэ. Үүнд:

- төрсний гэрчилгээний хуулбар
- суурь боловсролын гэрчилгээ
- хувийн хэрэг /шилжүүлсэн байх/
- төлбөр төлсөн баримт

14. Зарласан хугацаанд ирж бүртгүүлээгүй суралцагчийг тус сургуульд элсэхээс татгалзсан гэж үзэн, дараа өдрийн 10:00 цагаар тасалбар болгон онооны дарааллаар дараагийн шалгуулагчид элсэх эрхийг шилжүүлнэ.

15. Элсэгч суралцах эрхээ буцаах тохиолдолд сургалтын төлбөрийн 5%-тай тэнцэх төлбөр төлнө.